## ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНД, ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ /*2025 оны 11 сарын байдлаар*/

| № | Үзүүлэлт | Нэгж | 2024 он | 2025 он | Өсөлт бууралт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Төрсөн эх | Бодит тоо | 1091 | 1012 | -79 |
| 2 | Амьд төрсөн хүүхэд | Бодит тоо | 1097 | 1022 | -75 |
| 3 | Амьгүй төрсөн хүүхэд | Бодит тоо | 3 | 4 | 1 |
| | | 1000 нийт төрөлтөд | 2.7 | 3.9 | 1.2 |
| 4 | Эхийн эндэгдэл | Бодит тоо | 0 | 0 | 0 |
| | | 100 000 амьд төрөлтөд | 0 | 0 | 0 |
| 5 | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /0-4 нас 364 хоног/ | Бодит тоо | 19 | 20 | 1 |
| | | 1000 амьд төрөлтөд | 17.3 | 19.6 | 2.3 |
| 6 | Үүнээс: Нялхсын эндэгдэл /0-364 хоног/ | Бодит тоо | 18 | 14 | -4 |
| | | 1000 амьд төрөлтөд | 16.4 | 13.7 | -2.7 |
| | Үүнээс: Нярайн эндэгдэл /0-28 хоног/ | Бодит тоо | 11 | 13 | 2 |
| | | 1000 амьд төрөлтөд | 10.0 | 12.7 | 2,7 |
| | | Нялхсын эндэгдэлд эзлэх хувь | 61.1 | 92.9 | 31.8 |
| | Үүнээс: Нярайн эрт үеийн эндэгдэл /0-6 хоног/ | Бодит тоо | 11 | 7 | -4 |
| | | Нярайн эндэгдэлд эзлэх хувь | 100 | 53.8 | -46.2 |
| | Нярайн хожуу үеийн эндэгдэл /7-28 хоног/ | Бодит тоо | 0 | 6 | 6 |
| | | Нярайн эндэгдэлд эзлэх хувь | 0 | 46.2 | 46.2 |
| 7 | Перинаталь эндэгдэл | Бодит тоо | 14 | 11 | -3 |
| | | 1000 нийт төрөлтөд | 12.8 | 10.9 | -1.9 |
| 8 | Нийт нас баралт | Бодит тоо | 304 | 274 | -30 |
| 9 | Эмнэлгийн нас баралт | Бодит тоо | 71 | 93 | 22 |
| | | Хувь | 23.4 | 33.9 | 10.5 |
| 10 | Эмнэлэгт хоног болоогүй нас баралт | Бодит тоо | 35 | 36 | 1 |
| | | Хувь | 49.3 | 38.7 | -10.6 |
| 11 | Жирэмсний эрт хяналт | Хувь | 91.1 | 90.8 | -0.3 |
| 12 | Эмчлэгдсэн хүний тоо | Бодит тоо | 17836 | 14545 | -3291 |
| 13 | Ор хоног | Бодит тоо | 103174 | 91836 | -11338 |
| 14 | Халдварт өвчин | Бодит тоо | 1416 | 1389 | -27 |
| | | 10 000 хүнд | 187.7 | 180.4 | -7,3 |

# 1. Эх, хүүхдийн эрүүл мэнд

## 1.1 Төрөлт

Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 11 сарын байдлаар 1012 эх амаржиж 1022 хүүхэд мэндэлсэн ба төрөлт өмнөх үеийн мөн үеэс 79 тохиолдлоор буурсан байна .

Амьд төрсөн 1022 хүүхдийн:

- 518 буюу 50.7%нь эрэгтэй
- 504 буюу 49.3% нь эмэгтэй

Амьгүй төрөлт 4 бүртгэгдсэн нь өмнөх оноос 1 тохиолдлоор нэмэгдсэн байна. 2500 граммаас доош бага жинтэй 51 амьд төрсөн нярай нийт амьд төрөлтийн 5.0% ийг эзэлж өмнөх оны мөн үеэс 0.9%-р нэмэгдсэн.

Төрсөн эхчүүдийн 94.0% нь эмчийн хяналтын үзлэгт 6 ба түүнээс дээш удаа хамрагдсан байна. Нийт төрөлтийн 0.2 хувийг гэрийн төрөлт эзэлж байгаа ба Даланзадгад суманд бүртгэгдсэн байна.

Эхний 11 сарын байдлаар эхийн ноцтой хүндрэл 2 бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 2 тохиолдлоор буурсан байна.

2025 оны эхний 11 сарын байдлаар мэс заслын аргаар төрсөн эхчүүд **248 /24.5%/** эзэлж байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 3.1%-р өссөн үзүүлэлттэй байна.

Нийт төрөлтийн 42 буюу 4.2 хувийг охидын төрөлт эзэлж байгаа ба өнгөрсөн оны мөн үеэс 0.4 хувиар буурсан байна.



### 1.2 Хүүхдийн эндэгдэл

2025 оны эхний 11 сарын байдлаар нялхсын эндэгдэл 14 гарч 1000 амьд төрөлтөд 13.7 буюу өнгөрсөн оноос 2.7-р буурсан байна. 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 6 бүртгэгдсэн ба өмнөх оны мөн үеэс 5 тохиолдлоор өссөн үзүүлэлттэй байна.

**0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (бодит тоо, 1000 амьд төрөлтөд)**

| | Үзүүлэлтүүд | 2024-11 сар | | 2025-11 сар | | өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|---|
| | | Бодит тоо | түвшин | Бодит тоо | түвшин | |
| 1 | Амьгүй төрөлт | 3 | 2.7 | 4 | 3.9 | ↑ |
| 2 | Перинаталь эндэгдэл (Амьгүй төрсөн+168 цаг дотор эндсэн) | 14 | 12.8 | 11 | 10.9 | ↓ |
| 3 | Нярайн эндэгдэл (0-28 хоногтой) | 11 | 10.0 | 13 | 12.7 | ↑ |
| 4 | Нялхсын эндэгдэл (0-1 нас хүртэлх) | 18 | 16.4 | 14 | 13.7 | ↓ |
| 5 | 1-5 насны эндэгдэл | 1 | 0.9 | 6 | 5.9 | ↑ |
| 6 | 0-5 хүртлэх насны эндэгдэл | 19 | 17.3 | 20 | 19.6 | ↑ |

- **0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг харъяаллаар нь авч үзвэл:** **Гт-2, Цц-1, Цо-1, Бд-1,Бу-1, Эх-3 ,Но-1, Мн-1, Өо-1, Шб-2 тус тус эндсэн байна.**
- **1-5 насны хүүхдийн эндэгдлийг харъяаллаар нь авч үзвэл:** **Шб-2, Нн-1, Хү-1, Хб-1, Өо-1 тус тус эндсэн байна.**

**БОЭТ-ийн хүүхдийн эндэгдлийн мэдээлэл**

| | Үзүүлэлтүүд | 2024-11 сар | | 2025-11 сар | | өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|---|
| | | Бодит тоо | түвшин | Бодит тоо | түвшин | |
| 1 | Амьгүй төрөлт | 1 | 1.1 | 3 | 3.4 | ↑ |
| 2 | Перинаталь эндэгдэл (Амьгүй төрсөн+168 цаг дотор эндсэн) | 9 | 9.7 | 6 | 6.8 | ↓ |
| 3 | Нярайн эндэгдэл (0-28 хоногтой) | 8 | 8.6 | 9 | 10.1 | ↑ |
| 4 | Нялхсын эндэгдэл (0-1 нас хүртэлх) | 11 | 11.8 | 10 | 11.3 | ↓ |
| 5 | 1-5 насны эндэгдэл | 0 | 0 | 4 | 4.5 | ↑ |
| 6 | 0-5 хүртлэх насны эндэгдэл | 11 | 11.8 | 14 | 15.8 | ↑ |

## 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан (бодит тоогоор) /БОЭТ/

| Нас | | Перинаталь үед үүссэн эмгэг | | Уушги - зүрхний дутмагшил | | Бактерт мэнэн | | Осол гэмтэл | | Халдварт бус суулгалт | | Төрөлхийн гажиг | | Менингококкцеми, тодорхойгүй | | Бүгд | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2024 | 2025 | 2024 | 2025 | 2024 | 2025 | 2024 | 2025 | 2024 | 2025 | 2024 | 2025 | 2024 | 2025 | 2024 | 2025 |
| 1 хүрт лэх нас | 0-6 хоног | 8 | 3 | | | | | | | | | 3 | | | | **10** | **3** |
| | 7-28 хоног | | 6 | | | | | | | | | | | | | **0** | **6** |
| | 29-өөс дээш хоногтой | | | | | | 1 | | | | | | | | | **0** | **1** |
| 1-5 хүртэлх настай | | | | | | | | | 3 | | | | | | 1 | **0** | **3** |
| **Бүгд** | | **8** | **9** | **0** | **0** | **0** | **1** | **0** | **3** | **0** | **0** | **3** | **0** | **0** | **1** | **11** | **14** |

### 1.3 Эхийн эндэгдэл

Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 11 сарын байдлаар эхийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй. 2018 оноос хойш эхийн эндэгдэлгүй амжилттай сайн ажиллаж байна.

### 3.Эмнэлгийн тусламж үйлчилгээний үзүүлэлт

### 3.1 Амбулаторийн тусламж үйлчилгээ

Аймгийн хэмжээнд эхний 11 сарын байдлаар 410081 үзлэг хийгдэж өмнөх оны мөн үеэс 25679 үзлэгээр нэмэгдсэн байна. Нийт үзлэгийн 24.8 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 17.6 хувийг идэвхитэй хяналтын үзлэг,1.9 хувийг гэрийн дуудлагын үзлэг тус тус эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад идэвхитэй хяналтын үзлэг 1.7 хувиар өсч , урьдчилан сэргийлэх үзлэг 0.5 хувиар, гэрийн дуудлагын үзлэг 0.1 хувиар тус тус буурсан байна.




29

**Эмнэлгийн тусламж, үйлчилгээний зарим үзүүлэлтүүд 2025 оны эхний 11 сарын байдлаар**

| Сум/Өрх | Нийт үзлэг | Үүнээс | | | | | Бүртгэгдсэн өвчлөл | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Урьдчилан сэргийлэх үзлэг | Өвчний учир амбулат орт | Идэвхитэй хяналт | Гэрийн идэвхитэй | Гэрийн дуудлаг-аар | 2024 онд | 2025 онд |
| Баяндалай | 6376 | 1483 | 2417 | 1872 | 470 | 134 | 1277 | 1721 |
| Баян-Овоо | 4858 | 3853 | 584 | 29 | 307 | 85 | 403 | 505 |
| Булган | 2083 | 313 | 1570 | 47 | 78 | 75 | 123 | 128 |
| Гурвантэс | 10878 | 4076 | 4948 | 1778 | 12 | 64 | 1569 | 3126 |
| Мандал-Овоо | 1457 | 587 | 678 | 73 | 3 | 116 | 422 | 763 |
| Манлай | 5538 | 2287 | 1780 | 1053 | 259 | 159 | 1358 | 1220 |
| Номгон | 3815 | 1677 | 1488 | 419 | 98 | 133 | 946 | 1112 |
| Ноён | 6914 | 3073 | 2723 | 482 | 419 | 217 | 874 | 803 |
| Сэврэй | 3640 | 1697 | 1473 | 192 | 110 | 168 | 731 | 716 |
| Ханбогд | 14106 | 1806 | 11687 | 555 | 3 | 55 | 3546 | 1906 |
| Ханхонгор | 2461 | 1010 | 1300 | 20 | 75 | 56 | 921 | 1052 |
| Хүрмэн | 3756 | 2185 | 842 | 164 | 487 | 78 | 692 | 326 |
| Цогт-Овоо | 8947 | 5723 | 2810 | 278 | 88 | 48 | 43 | 368 |
| Цогтцэций | 25889 | 2549 | 17259 | 4463 | 511 | 1107 | 4560 | 5591 |
| БОЭТ | 158087 | 24466 | 100329 | 28088 | 26 | 5178 | 48419 | 52337 |
| Шимбилэг | 37662 | 13622 | 12313 | 5026 | 6657 | 44 | 4632 | 6851 |
| Өнө-орших | 16493 | 4218 | 7533 | 1642 | 3083 | 17 | 1005 | 2887 |
| Энхийн хүслэн | 35471 | 14792 | 9044 | 4449 | 7167 | 19 | 3651 | 5107 |
| Хувийн эмнэлэг | 60521 | 11533 | 47166 | 1810 | 4 | 8 | 14556 | 12616 |
| Цэргийн анги | 1129 | 874 | 197 | 28 | 8 | 22 | 0 | 0 |
| Нийт | 410081 | 101824 | 228141 | 52468 | 19865 | 7783 | 89728 | 99135 |

## 3.2 Хэвтэн үйлчлүүлэгчдийн тусламж үйлчилгээ

Аймгийн хэмжээнд эхний 11 сарын байдлаар 14545 хүн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 3291 хүнээр буурч, нийт 91836 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 6.3 байна. Хэвтэн эмчлүүлэгч 10000 хүн амд 1889.2 болж өмнөх

оны мөн үеэс 474.5-аар буурсан.




Нийт хэвтэн эмчлүүлэгчдийн 50.6 хувь нь БОЭТ-д, 30.8 хувь нь сумын эрүүл мэндийн төвүүдэд, 18.5 хувь нь хувийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн байна.

### 3.2.1 Стационарын тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд

| | | Орны тоо | Орны фонд ашиглалт | Орны фонд ашиглалтын хувь | Дундаж ор хоног | Орны эргэлт |
|---|---|---|---|---|---|---|
| № | Сум/хот | | | | | |
| 1 | Баяндалай | 12 | 107.7 | 32.2 | 8.2 | 13.2 |
| 2 | Баян-Овоо | 12 | 114.8 | 34.4 | 6.7 | 17.3 |
| 3 | Булган | 10 | 71.3 | 21.3 | 7.4 | 10.3 |
| 4 | Гурвантэс | 17 | 123.3 | 37 | 5.2 | 21.9 |
| 5 | Мандал-Овоо | 9 | 133.3 | 40 | 6.5 | 19.4 |
| 6 | Манлай | 13 | 124.6 | 37.3 | 6.7 | 18.5 |
| 7 | Номгон | 14 | 87.1 | 26 | 6.6 | 13.2 |
| 8 | Ноён | 11 | 136.1 | 41 | 6.7 | 20.3 |
| 9 | Сэврэй | 12 | 80 | 24.0 | 5.2 | 15.4 |
| 10 | Ханбогд | 37 | 132.2 | 39.6 | 6.8 | 19.9 |
| 11 | Ханхонгор | 9 | 140.4 | 42.0 | 6.9 | 20.3 |
| 12 | Хүрмэн | 10 | 155.2 | 46.5 | 7.1 | 22.2 |
| 13 | Цогт-Овоо | 13 | 97.3 | 29.1 | 5.3 | 18.6 |
| 14 | Цогтцэций | 45 | 181.4 | 54.3 | 6.6 | 27.6 |
| 15 | БОЭТ | 342 | 131.5 | 39.4 | 6.1 | 21.9 |
| 16 | Хувийн ортой эмнэлгүүд | 110 | 161.5 | 48.3 | 6.6 | 24.3 |
| 17 | ӨЭМТ-д | 9 | 0 | 0.0 | 0 | 0 |
| 18 | Цэргийн анги | 22 | 0 | 0.0 | 0 | 0 |
| 17 | Өмнөговь | 707 | 129.9 | 38.9 | 6.3 | 20.7 |

### 3.3 Үр хөндөлт:

Аймгийн хэмжээнд эхний 11 сарын байдлаар 352 үр хөндөлт бүртгэгдэж, өмнөх оноос 75 тохиолдлоор , 1000 амьд төрөлтөд 344.4 болж өмнөх оноос 44.8-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Өсвөр насны охидын үр хөндөлт- 26/7.4/% буюу өнгөрсөн оны мөн үеэс 2.5%-р өссөн байна. **/Бо-1,Нн-1,Сэ-1, Хб-1, Хх-1,Хү-1,Цо-1,Цц-2, Дз/ Эх-4,Шб-2,Өо-6/, бусад газар-3/** сумдад тус тус охидын үр

хөндөлт бүртгэгдсэн байна.




Нийт үр хөндөлтийн 212 буюу 60.2 %-ийг эмээр, 138 буюу 39.2%-ийг багажаар хийсэн. Багажаар хийсэн үр хөндөлт өмнөх оны мөн үеэс 3.0%-аар буурсан бол эмийн үр хөндөлт 2.3%-аар нэмэгдсэн.

### 3.4.Түргэн тусламжийн дуудлага

2025 оны эхний 11 сарын байдлаар түргэн тусламжийн 9543 дуудлага бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 536 тохиолдлоор нэмэгдсэн. Нийт дуудлагын 1282 буюу 13.4 хувийг алсын дуудлага , 791 буюу 8.3 хувийг осол гэмтлийн дуудлага эзэлж байна.

| № | Сум/боэт | Түргэн тусламжийн дуудлага | | | Бүх дуудлагад эзлэх хувь | Алсын дуудлагын эзлэх хувь | Осол, Гэмтлийн дуудлагын эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Бүгд | Алсын дуудлага | Осол, гэмтлийн | | | |
| 1 | Баяндалай | 134 | 32 | 15 | 1.4 | 23.9 | 11.2 |
| 2 | Баян-Овоо | 85 | 46 | 18 | 0.9 | 54.1 | 21.2 |
| 3 | Булган | 68 | 68 | 0 | 0.7 | 100 | 0 |
| 4 | Гурвантэс | 329 | 97 | 48 | 3.4 | 29.5 | 14.6 |
| 5 | Мандал-Овоо | 177 | 58 | 7 | 1.9 | 32.8 | 4.0 |
| 6 | Манлай | 216 | 57 | 19 | 2.3 | 26.4 | 8.8 |
| 7 | Номгон | 105 | 74 | 7 | 1.1 | 70.5 | 6.7 |
| 8 | Ноён | 97 | 58 | 10 | 1.0 | 59.8 | 10.3 |
| 9 | Сэврэй | 168 | 147 | 13 | 1.8 | 87.5 | 7.7 |
| 10 | Ханбогд | 235 | 120 | 51 | 2.5 | 51.1 | 21.7 |
| 11 | Ханхонгор | 334 | 117 | 9 | 3.5 | 35.0 | 2.7 |
| 12 | Хүрмэн | 224 | 66 | 6 | 2.3 | 29.5 | 2.7 |
| 13 | Цогт-Овоо | 114 | 60 | 23 | 1.2 | 52.6 | 20.2 |
| 14 | Цогтцэций | 1107 | 58 | 112 | 11.6 | 5.2 | 10.1 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | БОЭТ | 6074 | 224 | 453 | 63.6 | 3.7 | 7.5 |
| 16 | Шимбилэг | 40 | 0 | 0 | 0.4 | 0 | 0 |
| 17 | Өнө-орших | 17 | 0 | 0 | 0.2 | 0 | 0 |
| 18 | Энхийн хүслэн | 19 | 0 | 0 | 0.2 | 0 | 0 |
| 19 | Нийт | 9543 | 1282 | 791 | 100 | 13.4 | 8.3 |

### 3.5 Осол гэмтэл

2025 оны эхний 11 сарын байдлаар шинэ тохиолдол 1639 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 41 тохиолдлоор буурсан байна.

Осол гэмтэлд өртсөн тохиолдлын 77.0% (1255) нь эрэгтэй, 23.0% (384) нь эмэгтэй байна.







### 3.6 Жирэмсэн үеийн тусламж үйлчилгээ

2025 оны эхний 11 сард 1227 жирэмсэн эмэгтэйчүүдийг хяналтанд авсан нь өмнөх оны мөн үеэс 95 жирэмснээр буурсан . Жирэмсний эрт үеийн хяналт **90.8% болж өмнөх оны мөн үеэс 0.3%-р буурсан.**

Жирэмсэн эмэгтэйчүүдийн БЗДХ-ын шинжилгээнд хамрагдсан байдлыг авч үзвэл тэмбүү, ХДХВ халдвар илрүүлэх шинжилгээнд 100.0% хамрагдаж тэмбүүгийн халдварын 6 зэрэг тохиолдол бүртгэгдэж эмчилгээнд хамрагдсан.

Заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 92.6% хамрагдсан, трихомониаз илрүүлэх шинжилгээнд 92.0% нь хамрагдаж, зэрэг тохиолдол бүртгэгдээгүй байна.




## 3.7 ХАЛДВАРТ БУС ӨВЧИН:

Халдварт бус өвчний 99135 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 9407 тохиолдлоор, 10000 хүн амд 12876.5 болж өмнөх оны мөн үеэс 985.4-р тус тус нэмэгдсэн.



## 3.8 Халдварт бус өвчний эрт илрүүлэг, үзлэгийн мэдээ

Аймгийн хэмжээнд эхний 11 сарын байдлаар артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт 18-аас дээш насны 15835 хүн хамрагдсан ба 41.9 хувь нь эрэгтэй, 58.1 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр давтан үзлэгийн 109 хүнд буюу 15.2 хувьд нь артерийн гипертензи онош батлагдсан байна.

Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт 35-аас дээш насны нийт 14594 хүн хамрагдсанаас 40.8 хувь нь эрэгтэй, 59.2 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр давтан үзлэгийн 20 хүнд буюу 4.0 хувьд нь чихрийн шижин өвчний онош батлагдсан байна.

| | | Эрт илрүүлгийн мэдээ 2025.11 сар | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Эмнэлгийн нэр | Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг | | | Чихрийн шижингийн эрт илрүүлэг | | | Элэгний хавдарын эрт илрүүлэг/15-65/ | | | Умайн хүзүүний эсийн шинжилгээ | | | Хөхний үзлэгт хамрагдсан хүн | | | Дундаж хувь |
| | | хамрагдвал зохих | хамрагдсан | хамрагдсан хувь | хамрагдвал зохих | хамрагдсан | хамрагдсан хувь | хамрагдвал зохих | хамрагдсан | хамрагдсан хувь | хамрагдвал зохих | хамрагдсан | хамрагдсан хувь | хамрагдвал зохих | хамрагдсан | хамрагдсан хувь | |
| 1 | Баяндалай | 834 | 234 | 28.1 | 585 | 142 | 24.3 | 501 | 607 | 121.2 | 97 | 79 | 81.4 | 301 | 174 | 57.8 | 62.5 |
| 2 | Баян-овоо | 797 | 733 | 92.0 | 931 | 746 | 80.1 | 951 | 896 | 94.2 | 79 | 65 | 82.3 | 251 | 180 | 71.7 | 84.1 |
| 3 | Булган | 947 | 262 | 27.7 | 947 | 262 | 27.7 | 979 | 262 | 26.8 | 96 | 22 | 22.9 | 387 | 210 | 54.3 | 31.9 |
| 4 | Гурвантэс | 2922 | 1641 | 56.2 | 1860 | 1310 | 70.4 | 1930 | 1669 | 86.5 | 318 | 135 | 42.5 | 1423 | 434 | 30.5 | 57.2 |
| 5 | МандалОвоо | 665 | 665 | 100.0 | 665 | 665 | 100.0 | 755 | 558 | 73.9 | 74 | 22 | 29.7 | 175 | 133 | 76.0 | 75.9 |
| 6 | Манлай | 978 | 883 | 90.3 | 857 | 711 | 83.0 | 1132 | 1018 | 89.9 | 139 | 100 | 71.9 | 403 | 266 | 66.0 | 80.2 |
| 7 | Номгон | 1089 | 522 | 47.9 | 751 | 455 | 60.6 | 1181 | 508 | 43.0 | 88 | 66 | 75.0 | 310 | 212 | 68.4 | 59.0 |
| 8 | Ноён | 877 | 864 | 98.5 | 586 | 637 | 108.7 | 876 | 912 | 104.1 | 97 | 61 | 62.9 | 336 | 243 | 72.3 | 89.3 |
| 9 | Сэврэй | 646 | 647 | 100.2 | 440 | 441 | 100.2 | 814 | 434 | 53.3 | 90 | 91 | 101.1 | 291 | 156 | 53.6 | 81.7 |
| 10 | Ханбогд | 2700 | 997 | 36.9 | 514 | 724 | 140.9 | 2625 | 1097 | 41.8 | 1970 | 133 | 6.8 | 1330 | 253 | 19.0 | 49.1 |
| 11 | Ханхонгор | 918 | 317 | 34.5 | 616 | 275 | 44.6 | 970 | 460 | 47.4 | 94 | 82 | 87.2 | 321 | 292 | 91.0 | 61.0 |
| 12 | Хүрмэн | 880 | 880 | 100.0 | 634 | 777 | 122.6 | 780 | 560 | 71.8 | 87 | 42 | 48.3 | 262 | 207 | 79.0 | 84.3 |
| 13 | ЦогтОвоо | 1079 | 898 | 83.2 | 640 | 764 | 119.4 | 1175 | 1030 | 87.7 | 111 | 56 | 50.5 | 345 | 256 | 74.2 | 83.0 |
| 14 | Цогтцэций | 2800 | 920 | 32.9 | 2000 | 900 | 45.0 | 3000 | 1585 | 52.8 | 375 | 119 | 31.7 | 1550 | 562 | 36.3 | 66.2 |
| Сумын дүн | | 18132 | 10463 | 57.7 | 12026 | 8809 | 73.2 | 17669 | 11596 | 65.6 | 3715 | 1073 | 28.9 | 7685 | 3578 | 46.6 | 54.4 |
| 15 | Шимбилэг | 3116 | 1961 | 62.9 | 2409 | 1950 | 80.9 | 3188 | 1720 | 54.0 | 684 | 198 | 28.9 | 1920 | 1246 | 64.9 | 58.3 |
| 16 | ӨнөОрших | 3116 | 1311 | 42.1 | 2490 | 1201 | 48.2 | 2527 | 2259 | 89.4 | 320 | 136 | 42.5 | 1020 | 542 | 53.1 | 55.1 |
| 17 | Энхийн хүслэн | 3052 | 2100 | 68.8 | 2962 | 2634 | 88.9 | 2105 | 1366 | 64.9 | 407 | 165 | 40.5 | 1534 | 1091 | 71.1 | 66.9 |
| Өрхийн дүн | | 9284 | 5372 | 57.9 | 7861 | 5785 | 73.6 | 7820 | 5345 | 68.4 | 1411 | 499 | 35.4 | 4474 | 2879 | 64.3 | 59.9 |
| Нийт дүн | | 27416 | 15835 | 57.8 | 19887 | 14594 | 73.4 | 25489 | 16941 | 66.5 | 5126 | 1572 | 30.7 | 12159 | 6457 | 53.1 | 56.3 |
| 11 сарын өссөн | | 27416 | 15835 | 57.8 | 19887 | 14594 | 73.4 | 25489 | 16941 | 66.5 | 5126 | 1572 | 30.7 | 12159 | 6457 | 53.1 | 56.3 |

## 4. Хүн амын нас баралт

2025 оны эхний 11 сарын байдлаар аймгийн хэмжээнд 274 нас баралт бүртгэгдсэн ба өмнөх оны мөн үеэс 30 тохиолдлоор буурсан байна.

Нийт нас баралтын 171/62.4%/ нь эрэгтэй, 103/37.6%/ нь эмэгтэй байна . Нийт нас барсан хүний 15.3% нь хорт хавдар,18.6% нь осол гэмтлийн нас баралт, 7.3% нь зүрхний шигдээс, тархинд цус харвалт зэрэг сэргийлж болох эндэгдлээр нас барсан байна.

Нийт нас баралтын 33.9% нь эмнэлэгт нас барсан ба 36 тохиолдол буюу 38.7 хувийг хоног болоогүй нас баралт эзэлж байна. Эмнэлэгт хоног болоогүй нас баралт өмнөх оны мөн үеэс 22 тохиолдлоор өссөн байна.







Нас баралтын түвшин 10000 хүн амд 35.6 байна.

Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 51 бүртгэгдэж нийт нас баралтын 18.6 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеэс 17 тохиолдлоор өссөн бөгөөд 10000 хүн амд ногдох осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 6.6 байна.




## 5. ХАЛДВАРТ ӨВЧИН

Халдварт өвчний 1389 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 180.4 байна . Халдварт өвчний шалтгаант нас баралт -2 бүртгэгдсэн.

### Халдварт өвчний бүтцийн хувьд авч үзвэл:

Нийт халдварт өвчний 539 /38.8%/-г БЗДХ, 244 /17.6%/-г салхинцэцэг, 379 /27.3%-г улаанбурхан өвчин, 72 /5.2%/-г хоолны хордлого, 38 /2.7%/-г цусан суулга, 20 /1.4%/-г улаан эсэргэнэ, 60 /4.3%/-г гар хөл амны өвчин, 6 /0,4%/-г ёлом, 20 /1.4%/-г сүрьеэ, 2 /0.1%/ -г вируст гепатит, 4 /0,3%/-г сальмонеллт, 1 /0,1%/-г арьс мөөгөнцөртөх өвчин, 2 /0.1%/-г халдварт эритема, 1 /0,1%/-г менингококкцеми тодорхойгүй, 1 /0,1%/-г -толбот чичрэг зэрэг өвчнүүд тус тус ээлж байна.

**Бэлгийн дамаар дамжих халдвар, хувиар** **бусад халдварт өвчин**






## АНХААРАЛ ТАТСАН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

1.1-5 насны хүүхдийн эндэгдэл 6 бүртгэгдсэн ба өмнөх оны мөн үеэс 5 тохиолдлоор өссөн байна. Нийт эндсэн хүүхдийн 5-осол гэмтлийн шалтгаантай, 1-халдварт өвчний шалтгаантай байна.

2.БЗДХ-ын 539 тохиолдол бүртгэгдсэн ба үүнээс өсвөр насны /14-19/ хүүхдийн 110 тохиолдол бүртгэгдсэн байна.

3.Халдварт өвчний шалтгаант нас баралт -2 бүртгэгдсэн байна.

4. Осол гэмтэл болон гадны шалтгаант нас баралт өмнөх оны мөн үеэс 17 тохиолдлоор өссөн байна.

5. Эмнэлгийн нас баралт өмнөх оны мөн үеэс 22 тохиолдлоор өссөн үзүүлэлттэй байна.

МЭДЭЭЛЭЛ БЭЛТГЭСЭН: ХШҮМХ-ийн статистикч О.Хандармаа, Ш.Нарандалай